

- 5.55. Холбоо нь тамирчид, дасгалжуулагч, шүүгчид ёс зүй, сахилгын дүрмийг зөрчсөн эсэхийг магадлан шийдвэрлэх үүрэг бүхий 5 гишүүний бүрэлдэхүүнтэй ёс зүйн зөвлөлтэй байна.
- 5.56. Ерөнхийлөгчийн саналыг үндэслэн удирдах зөвлөлөөс Ёс зүй зөвлөлийн гишүүнийг 2 жилийн хугацаатай томилно. Ёс зүйн зөвлөл нь ажлаа Удирдах зөвлөлд тайлагнана.
- 5.57. Ёс зүйн зөвлөлийн гишүүнийг нэг удаа улираан томилж болох бөгөөд бусад зөвлөлд сонгогдож ажиллахыг хориглоно.
- 5.58. Ёс зүйн зөвлөлийн үндсэн үйл ажиллагаа нь хуралдаан байх бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.
- 5.59. Холбооны ёс зүй дүрмийг удирдах зөвлөл батална.

### **ЗУРГАА. ХОЛБООНЫ ГИШҮҮН, ТҮҮНИЙ ЭРХ ҮҮРЭГ**

- 6.1. Дараахь этгээдүүд нь Холбооны гишүүн байж болно.
  - 6.1.1. Аймаг, нийслэл, дүүргийн Холбооны салбар зөвлөл;
  - 6.1.2. Уулсын спортын аль нэг төрөл, эсхүл орон нутгийн холбоод;
  - 6.1.3. Уулсын спортын бөгөөд аялалын клуб;
  - 6.1.4. Холбооноос зөвшөөрсөн бусад багууд;
  - 6.1.5. Тамирчид, дасгалжуулагч болон шүүгчид.
- 6.2. Энэ дүрмийн 6.1-т заасан этгээд болон Холбооноос тогтоосон болзол, шалгуурыг хангасан дотоод, гадаадынхуулын этгээд, байгууллага, иргэний хүсэлтийг Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авч Удирдах зөвлөлийн шийдвэрээр Холбооны гишүүнээр элсүүлнэ.
- 6.3. Холбооны гишүүн дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:
  - 6.3.1. Бүх гишүүдийн хуралд оролцож хэлэлцэж буй асуудлаар саналын эрхтэй оролцох ба саналын эрхийн тоог Удирдах зөвлөл гишүүнчлэлийн журмаар зохицуулна;
  - 6.3.2. Холбооноос зохион байгуулж буй болон холбооны эсхүл улсын нэрийн өмнөөс гадаад, дотоодын тэмцээн уралдаанд оролцох;
  - 6.3.3. Холбооноос зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, өөрсдийн зохион байгуулах арга хэмжээнд холбооноос мэргэжлийн туслалцаа, хөнгөлөлт авах;
  - 6.3.4. Өөрийн эрх, ашиг сонирхолтой холбоотой асуудлаар холбооны удирдаанд саналаа гаргах;
  - 6.3.5. Гишүүний татварыг төлөх;
  - 6.3.6. Холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, шаардлагатай мэдээлэл, судалгаагаар холбооны удирдлага болон мэргэжлийн болон хяналтын зөвлөлийг хангаж ажиллах;
  - 6.3.7. Холбооны дүрэм, удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийг биелүүлэх, өөрт ногдсон үүргийг цаг хугацаанд нь гүйцэтгэх;
- 6.4. Гишүүн нь 2 жил ба түүнээс дээш хугацаанд гишүүний хураамжаа төлөөгүй бол Удирдах зөвлөлийн шийдвэрээр түүнийг холбооны гишүүнээс хасна.
- 6.5. Холбооны гишүүнээс өөрийн хүсэлтээр гарагыг хүссэн этгээд нь хүсэлтээ удирдах зөвлөлд гаргах бөгөөд Холбооны өмнө хүлээсэн аливаа үүрэг, хариуцлага байхгүй бол түүнийг удирдах зөвлөлийн шийдвэрээр хасна.

БҮРГЭЭЛИЙН РИЙВ  
Гарын чадлыг  
20.08.2018  
ХУУЛСАН  
Б.ОЧИХАСАА